

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 01 ДҮГЭЭР ХУРАЛ**

Хурлыг 2013 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 14 цаг 15 минутад эхэлж, 17 цаг 30 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 3 цаг 15 минут хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1.	Улсын сайн малчин, тэргүүний тариаланч шалгаруулах	<p>Улсын сайн малчнаар</p> <ol style="list-style-type: none"> 1. Чандмань сумын Сүлжээ багийн малчин Дэжидийн Дашням 2. Зэрэг сумын Бураа багийн малчин Довдонгийн Сүхбат 3. Дуут сумын Хөхбэлчир багийн малчин Бямбажавын Амгаланбаатар нарыг Алтан төлийн эзнээр <p>1. Эрдэнэбүрэн сумын Харус багийн малчин Баядолын Телеуханыг шалгаруулж нэрийг нь Тэргүүний тариалангчаар</p> <ol style="list-style-type: none"> 1. Жаргалант сумын Ш.Илкен, 2. Ховд сумын Улаанбураа багийн Б.Адилхан, 3. Буянт сумын Норжин хайрхан багийн Г.Боролхаан нарын нэрийг аймгийн ИТХТ-д уламжлахаар шийдвэрлэв.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 02 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2013 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10 цаг 30 минутад эхэлж, 14 цаг 30 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 4 цаг хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
	Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийх, зургийн даалгавар	15 мянган га талбай байхаар төлөвлөж 02 сарын 15-ны дотор гүйцэтгэгч компанийг шалгаруулах. 06 дугаар сарын 01 гэхэд дууссан төлөвлөгөө бэлэн болсон байх.
	Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт	Өмнө байгаа сайн ажлуудыг улам сайжруулах, орон нутгийн хөгжлийн сангаас гарах ажлуудыг яаралтай гаргах, зураг төсвийн сан байгуулж зураг төсвийг урьдчилж бэлэн болгож байх. Барилгын санхүүжилтийг 40/40/20 гэж олгоё. Аймгийн тендерийн урилгыг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байх

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 03 ДУГААР ХУРАЛ**

Хурал 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цаг 30 минутад эхэлж, 19 цаг 00 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 4 цаг 30 минут хуралдав.

д\д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1.	Аймгийн сайн малчин, тэргүүний тариаланч шалгаруулах	Зэрэг Булган сумуудад нэг нэг малчин нэмж оруулан нийт 22 малчин болгох. /малчдын нэрс хавсралтаар/ Шаардлага хангасан 4 тариаланчийг шалгаруулахаар шийдвэрлэв.
	“Аймгийн тэргүүний хоршоо” шалгаруулах	Тэргүүний хоршоогоор Мөст сумын Баян төл, Үенч сумын Малчны ирээдүй хоршоог шалгаруулав. Тэргүүний фермерээр Жаргалант сумын иргэн Батхуяг, Энхтайван нар шалгарав.
	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөл бөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	Төлөвлөгөөг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээд аймгийн ИТХТ-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.
	“Батлан хамгаалах арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж шалгах, сургалт явуулах зардлын тухай”	Төсөвт төлөвлөгдсөн байдаг тул дэмжигдлээ.
	“Замын цагдаагийн тасгийн дарга Д.Энхбаатарын хувийн өргөдлийг хэлэлцэх”	Аймгийн ЗДТГ-ын албан бичгээр Аймгийн Цагдаагийн даргад бичиг явуулж 4 сарын 15-наас тус байранд гэрээгээр оруулахаар шийдвэрлэх.
	“Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж шалгах ажлын төлөвлөгөө”	Хойшлуулж бусад хэлтсүүдийн төлөвлөгөөтэй нэгтгэн оруулж ирэхээр шийдвэрлэв.
	Олон нийтийн статустай “Ховд телевиз”-ийн үйл ажиллагаатай танилцсан ажлын хэсгийн дүгнэлт	Хэрхэн шийдвэрлэх тогтоолын төслийг боловсруулаад аймгийн ИТХТ-д өргөн барьж шийдвэрлүүлэх.
	Эрх зүйн сургалт сурталчилгааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Аймгийн иргэдийн хурлын Тэргүүлэгчдэд өргөн барих.
	Хөрөнгө гаргах тухай захирамжийн төсөл	Зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжив.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 04 ДҮГЭЭР ХУРАЛ**

Хурлыг 2013 оны 02 дүгээр сарын 05-ний өдрийн 14 цаг 40 минутад эхэлж, 16 цаг 00 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 40 минут хуралдав.

Д/д	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Луу жилийн Аймгийн 9 алдартан шалгаруулах	9 алдартныг дэмжив.
2	Хөрөнгө гаргах тухай захирамжийн төсөл	Захирамжийн төсөл дэмжигдлээ.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 05 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2013 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 14 цаг 20 минутад эхэлж, 18 цаг хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 3 цаг 40 минут хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Ховд аймгийн Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл	ШИЙДВЭРЛЭСЭН НЬ 1: Эдгээр саналыг тусган нэгтгэж батлуулах
2	Ярант хилийн боомтод тээврийн байцаагч, зохицуулагч нарын байрны гаднах хашааны төсөл	Хөгжлийн бодлогын хэлтэс дээр үлдээгээд давсан орлого хэлэлцэх үед нь дахин оруулж хэлэлцүүлье.
3	Аймгийн 2013 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө	Дээрх саналуудыг тусган батлуулах
4	Хөрөнгө гаргах тухай	Захирамжийн төсөл нийт 1050000 төгрөг. Хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулах гэрээний төсөл. Улаанбаатар хотруу явах 3 даргын зардал, Сүхбаатар аймагт туршлага судлах зардалуудыг шийдэх. Засаг даргын захирамжаар шийдвэрлэхээр санал нэгтэй батлав.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 06 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2013 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 13 цагт эхэлж, 15 цаг хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, 2 цаг хуралдав.

д\д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1.	Аймгийн тохижилт үйлчилгээний “Эрч хүч” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай, ИТХТ-д өргөн барих дүрмийн төсөл	“Эрч хүч” Компаний дүрэмд өөрчлөлт оруулан аймгийн ИТХ-д өргөн барихаар шийдвэрлэв.
2.	“Шугам сүлжээ” аж ахуйн тооцоот орон нутгийн өмчит газар байгуулах тухай	“Шугам сүлжээ” компаний тухай гишүүд ярилцаад түр хойшлуулсан нь дээр гэж үзлээ.
3	“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барихаар гишүүд санал нэгтгэйгээр шийдвэрлэв.
4	Аймгийн “Алтан өв” хөтөлбөр	Гишүүд санал нэгтгэйгээр батлан Аймгийн ИТХ-д өргөн барихаар шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР